



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/72

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 51, 288 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 388 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй амины орон сууцны зориулалттай дуусаагүй барилгыг дуудлагын худалдаагаар худалдан авсан иргэн Дашийн Сайнхүүд дуусаагүй барилгыг эзэмшил газрын хамт газар дээр нь хүлээлгэн өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

В.Дарханбаатар -Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга

Гишүүд:

Д.Одмаа -Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн


Д.Дариймаа -Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Х.Базаррагчаа -Жолооч

2. Дуудлагын худалдаагаар худалдсан дуусаагүй барилгыг хүлээлцсэн хувьчлалын тайланг газрын хуралдаанд оруулан батлуулахыг Ажлын хэсэг /В.Дарханбаатарт/-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



132018677